



A/A

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/150

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах,
хаягийн өөрчлөлт бүртгэх тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 8.1 дүгээр зүйлийн 13.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12, 9 дүгээр зүйлийн 9.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3, 19.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба байгуулах тухай" A/132 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн комиссын ажлын албаны 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 06 дугаар хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллагын жагсаалтыг нэгдүгээр, хаягийн өөрчлөлт бүртгэх байгууллагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Г.Цэцэнсанаа)-т, Чанарын хяналтын газар (Ч.Отгонцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЭРДЭНЭБАЯР


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2025
оны 07 дугаар сарын 07 -ний
өдрийн 150 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хугацаа
1.	Эгшиглэнт хөгжил фарм ХХК РД: 6617336	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	ЧД, 2-р хороо, Бэриш төв, 5 давхар 501 тоот	2030.06.08
2.	Күсүри жапан ХХК РД: 6793886	Эм импортлох-ханган нийлүүлэх	БЗД, 4-р хороо, 15-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 61/1 тоотын 1 давхар	2030.06.08
3.	Төв цогт ХХК РД: 6494889	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, импортлох-ханган нийлүүлэх	БГД, 20-р хороо, Үйлдвэрийн бүс, /16102/ Өөрийн байр	2030.06.08

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2025
оны 07 дугаар сарын 07-ний
өдрийн 10 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Өмнөх хаяг	Хаяг байршил	Хугацаа
1.	Төв цогт ХХК РД: 6494889	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, импортлох-ханган нийлүүлэх	БГД, 1-р хороо, 2-р хороолол, Жонбээс төв байр 202 тоот	БГД, 20-р хороо, Үйлдвэрийн бүс, /16102/ Өөрийн байр	2030.06.08